БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: БНА-2020/55/СТА-ТШЗ**


Цахим хуудас:
Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


Аудитын гэрчилгээ ........ 3

Аудитын тайлан........ 5

2.1. Оршил ........ 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт........ 5

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 5

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал........ 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 6

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 6

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 7

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 8

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 8

2.13. Шилэн дансны мэдээлэл........ 8

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 9

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл........ 9

Менежментийн захидал ........ 10

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 11

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 14

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 16

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 17

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан........ 20

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.04 № 1/43

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР СУМЫН НОМГОН АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.САРАНГЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

C:\Users\audit_bhr3\Downloads\Аудитын гэрчилгээ (3).docx

005020003

2

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

C:\Users\audit_bhr3\Downloads\Аудитын гэрчилгээ (3).docx

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн менежер Л.Сарангэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.25-наас 2020.01.31–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Номгон ахлах сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.15-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь " Сурах хүсэл сонирхолтой, бие даан суралцах чадвартай, эрүүл, зөв дадал хэвшилтэй, бусдыг ойлгож хүндэлдэг суралцагчийг төлөвшүүлнэ." гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, хүүхдийн хэрэгцээ сонирхлыг харгалзан адил тэгш хангах
- Сургалтын алба, мэргэжлийн зөвлөлөөр хамтран ажлын байран дээр мэргэжил, заах арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх
- Сургалтын амжилтыг өмнөх жилийнхээс 5-10 хувиар ахиулж , чанарын үнэлгээний шалгалт болон ЭЕШ-ын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, дундаж оноог ахиулах
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжлийн асуудлаар эцэг, эх, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль болох
- Насан туршийн боловсролын үйлчилгээг хамран сургах тойргийн иргэдэд хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын Номгон ахлах сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2485478,5 мянган төгрөгөөс тооцон 24854,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 24854,8 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65675,5 мянган төгрөгөөр буюу 2,1%-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага дансны үлдэгдэл 7815,1 мянган, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 83248,1 мянган төгрөгөөр тус тус буурсан, бараа

материалын дансны үлдэгдэл 25387,7 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0,00 | 0,00 | |
| Авлага | 7824,7 | 9,6 | -7815,1 |
| Урьдчилгаа | 0,00 | 0,00 | 0,00 |
| Бараа материал | 98574,4 | 123962,1 | 25387,7 |
| Үндсэн хөрөнгө | 3083691,5 | 3000443,4 | -83248,1 |
| **Нийт хөрөнгө** | 3190090,6 | 3124415,1 | -65675,5 |
| Өр төлбөр | 0,00 | 0,00 | 0,00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2498705,8 | 2498705,8 | 0,00 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3190090,6 | 3124415,1 | -65675,5 |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь дээрх авлага нь НДШ-ийн тооцоог тухай бүр үнэн зөв хийгээгүйгээс НДШ-ийн илүү төлөлттэй холбоотой үүссэн авлага байсан бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар НД-ын байгууллагатай өр, авлагын тооцоог тухай бүр хийж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласнаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон байгууллага ,хувь хүнээс авах авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь сурагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, эм, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс гадна БСШУС-ын яамнаас 15009,0 мянган төгрөгийн ном ирсэн нь шалтгаалжээ. Оны эцэст эмийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хуваарьтай холбоотой 5099,4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, шүдний материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.12.25-ны өдрийн 129 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 129872,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 55288,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БСШУС-ын яамнаас 23571,9 мянган төгрөгийн ном, Дэлхийн зөн ОУБ-аас 4131,3 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан, төсөвт тусгагдсанаар 16969,9 мянган төгрөгийн, нэмэлт орлогын эх үүсвэрээр 10615,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус худалдан авсан байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй, биет бус хөрөнгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй ,Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор сумын Номгон ахлах сургуульд тайлант онд орлого төвлөрүүлэх төсөв батлагдаагүй, харин гүйцэтгэлээр төсөвт байгууллагын өөрийн орлогоор 23893,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, аймгийн ТЕЗ-чийн эрх олгосон шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2337172,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2337172,2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2337172,2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2334495,6 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 2676,6 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлсэнээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 2000,0 мянган, дээд шатны байгууллагаас 10099,7 мянган, үндсэн бус үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28043,9 мянган, нийт 38144,2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал үйл ажиллагааны зардалд 38143,7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0,5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1032,1 мянган төгрөгиийн алдаа, зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоож, биет бус хөрөнгийн ашиглалтыг сайжруулахтай холбоотой 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1032,1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Сургуулийн захиралын 2019.02.11-ний Б/15 тоот тушаалаар цалинг 20,0%-иар 2 сарын хугацаатай хасах сахилгын шийтгэл ногдуулсан Ж.Даваадоржид 1-4-р улирлын , 2019.10.22-ний Б/130 тоот тушаалаар цалинг 10,0%-иар 2 сар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан багш С.Мөнхтуул, Ц.Ариунсан нарт 4-р улирлын үр дүнгийн урамшууллыг олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3. " Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт,хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар батлагдсан орон тооноос 6 орон тоо илүү ажилласанд суралцагчийн тоо нэмэгдэж анги бүлгийн тоо нэмэгдсэнтэй холбоотой гэсэн тайлбарыг төсвийн менежер ирүүлсэн тул энэ асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараахь байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | 2 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | 2 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 78 | 18 | |
| | Нийт | 27 | 151 | 126 | 23 | 2 |

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2478,3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж ажилласан байна.

Нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100,0 хувьтай байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Биет бус хөрөнгө данстай холбоотой асуудал*

**1.1.** ***<u>Илрүүлэлт:</u>*** Тус байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгүүдийн ашиглалтын байдлыг судалж үзэхэд 286,3 мянган төгрөгийн үнэтэй монгол бичгийн программ, 300,0 мянган төгрөгийн үнэтэй математикийн зориулалттай сургалтын гарын авлага CD, 2000,0 мянган төгрөгийн үнэтэй эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох программууд системийн хоцрогдолд орсон гэсэн шалтгаанаар ашиглалтгүй, 1875,0 мянган төгрөгийн үнэтэй Server dell t11 DVD-RV- БУМСистемийн сургуулийн мэдээллийн дотоод серверь нь Боловсролын яамнаас холболт хийж өгөөгүй гэсэн шалтгаанаар тус тус ашиглалтгүй байна.

***1.2.*** ***<u>Эрсдэл:</u>***
Хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг гарахгүй байх

***1.3.*** ***<u>Өгсөн зөвлөмж</u>***:
Дээрх биет бус хөрөнгийг ашиглаж болох эсэхийг системийн дээд байгууллага болон бусад эрх бүхий байгууллагад хандан дүгнэлт гаргуулах, ашиглах боломжгүй тохиолдолд бүртгэлээс хасах арга хэмжээ авах

***1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>***

*Зөвшөөрсөн*

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-1А**

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **106,399,099.69** | **123,971,676.01** |
| **33** | **АВЛАГА** | 7,824,751.87 | 9,600.37 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 7,824,751.87 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 9,600.37 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 9,600.37 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 98,574,347.82 | 123,962,075.64 |
| **351** | **Түүхий эд материал** | 245,400.00 | 19,129,800.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 15,009,000.00 |
| 35130 | Эм боох материал | 245,400.00 | 4,120,800.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 11,670,700.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 86,658,247.82 | 104,832,275.64 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,171,000.00 | 7,076,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 556,880.00 | 9,921,480.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.32 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,087,423.00 | 1,682,423.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 82,842,944.50 | 86,152,272.64 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,083,691,487.03** | **3,000,445,415.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,083,691,487.03 | 3,000,445,415.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,211,116,487.03 | 2,127,870,415.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,074,238,564.50 | 2,074,238,564.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -44,427,253.64 | -123,646,188.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 518,248,545.62 | 425,381,556.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -426,284,578.94 | -359,080,972.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 132,778,135.27 | 139,347,355.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -90,852,655.90 | -87,500,157.94 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 47,110,730.12 | 32,413,358.00 |
| 39217 | Ном | 305,000.00 | 26,716,900.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 872,575,000.00 | 872,575,000.00 |
| 39301 | Програм хангамж | 5,878,998.00 | 5,878,998.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,878,998.00 | -5,878,998.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 872,575,000.00 | 872,575,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,190,090,586.72** | **3,124,417,091.17** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,190,090,586.72** | **3,124,417,091.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,190,090,586.72 | 3,124,415,091.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,498,705,779.83 | 2,498,705,779.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,498,705,779.83 | 2,498,705,779.83 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -2,464,035,496.44 | 2,529,710,991.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -2,464,035,496.44 | 2,464,035,496.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -65,673,495.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,155,420,303.33 | 3,155,420,303.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,190,090,586.72** | **3,124,417,091.17** |

### 1.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,009,623,310.30** | **2,419,803,031.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **37,339,430.60** | **66,379,631.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 37,339,430.60 | 66,379,631.54 |
| 120004 | Төсөв байгууллагын өөр орлого | 37,339,430.60 | 66,379,631.54 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 450,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,928,260.00 | 21,443,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй авсан орлого | 34,411,170.60 | 44,486,631.54 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **73,400,579.70** | **335,389,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,898,883,300.00 | 2,018,033,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 38,320,286.70 | 16,251,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,320,286.70 | 12,099,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,151,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 319,138,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 319,138,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,080,293.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 35,080,293.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,201,352,975.80** | **2,470,554,139.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,201,352,975.80** | **2,470,554,139.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,001,478,795.80 | 2,344,161,511.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,218,429,336.00 | 1,629,448,190.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 964,218,748.00 | 1,448,822,639.00 |
| 210102 | Нэмэгдэл | 182,254,989.00 | 180,625,551.00 |
| 210104 | Урамшуулал | 71,955,599.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,907,630.00 | 205,609,523.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 156,907,630.00 | 140,465,650.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 16,684,003.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 13,107,309.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 3,287,974.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 32,064,587.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 332,248,400.00 | 312,638,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,137,600.00 | 14,414,458.00 |
| 210302 | Түлш, халаалт | 282,985,385.00 | 262,454,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35,125,415.00 | 35,769,942.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,758,336.00 | 47,814,250.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,291,800.00 | 5,375,590.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,118,400.00 | 2,161,800.32 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,465,516.00 | 2,947,804.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 32,600.00 | 36,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 270,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,850,020.00 | 3,981,580.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 33,041,476.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 169,700.00 | 1,224,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 169,700.00 | 1,224,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,502,000.00 | 5,694,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,502,000.00 | 5,694,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 611,000.00 | 1,387,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 611,000.00 | 1,387,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,541,886.70 | 11,251,236.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,541,886.70 | 10,651,236.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 260,310,507.10 | 129,093,911.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,030,263.21 | 1,974,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,550,000.00 | 3,506,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 254,730,243.89 | 123,612,661.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 199,874,180.00 | 126,392,628.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 199,237,643.00 | 123,715,550.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 35,080,293.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 101,365,850.00 | 106,421,550.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 61,791,500.00 | 10,099,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 7,194,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 636,537.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 636,537.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 506.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 506.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,676,572.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,676,572.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-191,729,665.50** | **-50,751,107.69** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 131,085,600.57 | 14,924,387.88 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 927,596.11 | 14,924,387.88 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 130,158,004.46 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -131,085,600.57 | -14,924,387.88 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-322,815,266.07** | **-65,675,495.57** |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,975,212,139.70** | **2,389,844,005.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,928,260.00** | **21,893,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,928,260.00 | 21,893,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,928,260.00 | 21,893,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 450,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,928,260.00 | 21,443,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,972,283,879.70** | **2,367,951,005.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,898,883,300.00 | 2,018,033,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 38,320,286.70 | 16,251,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,320,286.70 | 12,099,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,151,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 319,138,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 319,138,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,080,293.00 | 14,527,605.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 35,080,293.00 | 14,527,605.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,975,212,139.70** | **2,362,258,205.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,975,212,139.70** | **2,362,258,205.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,775,337,959.70** | **2,221,521,972.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,224,523,837.00 | 1,615,720,904.00 |
| 210101 | Үндсэн цалин | 970,343,248.00 | 1,202,414,179.00 |
| 210102 | Нэмэгдэл | 182,224,989.00 | 246,779,279.00 |
| 210104 | Урамшуулал | 71,955,600.00 | 166,527,446.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,280,700.00 | 203,348,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 152,280,700.00 | 148,440,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 13,726,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 10,981,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 2,745,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 27,454,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 332,248,400.00 | 312,638,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,137,600.00 | 14,414,458.00 |
| 210302 | Түлш, халаалт | 282,985,385.00 | 262,454,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35,125,415.00 | 35,769,942.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,933,336.00 | 19,789,974.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,259,000.00 | 6,023,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,118,400.00 | 2,161,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,465,516.00 | 2,977,804.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 561,600.00 | 2,057,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 465,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,528,820.00 | 6,104,580.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 924,600.00 | 7,944,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 245,400.00 | 5,273,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 679,200.00 | 2,671,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,721,000.00 | 15,244,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,630,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 230,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,721,000.00 | 10,384,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 611,000.00 | 1,387,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 611,000.00 | 1,387,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,541,886.70 | 20,821,494.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,541,886.70 | 20,221,494.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 36,553,200.00 | 24,626,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,733,500.00 | 7,094,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,819,700.00 | 17,532,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **199,874,180.00** | **140,736,233.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 199,237,643.00 | 138,059,155.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 35,080,293.00 | 14,527,605.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 101,365,850.00 | 106,421,550.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 61,791,500.00 | 10,099,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 7,010,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 636,537.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 636,537.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 506.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 506.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,676,572.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,676,572.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **27,585,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **27,585,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **27,585,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 27,585,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 27,585,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-27,585,800.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-4А**

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,498,705,779.83** | **3,155,420,303.33** | **-2,464,035,496.44** | **00.00** | 3,190,090,586.72 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,498,705,779.83** | **3,155,420,303.33** | **-2,464,035,496.44** | **00.00** | 3,190,090,586.72 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,498,705,779.83** | **3,155,420,303.33** | **-2,464,035,496.44** | **00.00** | 3,190,090,586.72 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -65,675,495.57 | 00.00 | -65,675,495.57 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,498,705,779.83** | **3,155,420,303.33** | **-2,529,710,992.01** | **00.00** | 3,124,415,091.15 |

### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,912,465,496.00 | 1,912,465,496.00 | 2,337,172,200.00 | 2,334,495,628.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,912,465,496.00 | 1,912,465,496.00 | 2,337,172,200.00 | 2,334,495,628.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,743,656,573.00 | 1,743,656,573.00 | 2,223,081,000.00 | 2,221,063,778.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,224,523,837.00 | 1,224,523,837.00 | 1,615,738,100.00 | 1,615,720,904.00 |
| 210101 | Үндсэн цалин | 970,343,248.00 | 970,343,248.00 | 1,193,593,900.00 | 1,202,414,179.00 |
| 210102 | Нэмэгдэл | 182,224,989.00 | 182,224,989.00 | 249,550,000.00 | 246,779,279.00 |
| 210104 | Урамшуулал | 71,955,600.00 | 71,955,600.00 | 172,594,200.00 | 166,527,446.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,280,700.00 | 152,280,700.00 | 203,348,400.00 | 203,348,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 152,280,700.00 | 152,280,700.00 | 148,440,700.00 | 148,440,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 13,726,800.00 | 13,726,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 10,981,600.00 | 10,981,600.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 2,745,300.00 | 2,745,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 27,454,000.00 | 27,454,000.00 |
| **2103** | **Байр ашиглалт-тай холбоотой тогтмол зардал** | 332,248,400.00 | 332,248,400.00 | 312,638,600.00 | 312,638,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,137,600.00 | 14,137,600.00 | 12,978,900.00 | 14,414,458.00 |
| 210302 | Түлш, халаалт | 282,985,385.00 | 282,985,385.00 | 263,381,700.00 | 262,454,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35,125,415.00 | 35,125,415.00 | 36,278,000.00 | 35,769,942.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,933,336.00 | 9,933,336.00 | 23,555,000.00 | 21,554,974.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,259,000.00 | 2,259,000.00 | 6,950,800.00 | 6,023,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,118,400.00 | 1,118,400.00 | 2,176,800.00 | 2,161,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,465,516.00 | 2,465,516.00 | 3,116,400.00 | 2,977,804.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 561,600.00 | 561,600.00 | 4,753,600.00 | 3,822,000.00 |
| 210405 | Хог хаягдал зай-луулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 450,000.00 | 465,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,528,820.00 | 3,528,820.00 | 6,107,400.00 | 6,104,580.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 924,600.00 | 924,600.00 | 7,944,900.00 | 7,944,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 245,400.00 | 245,400.00 | 5,417,300.00 | 5,273,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 679,200.00 | 679,200.00 | 2,527,600.00 | 2,671,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засвар** | 4,721,000.00 | 4,721,000.00 | 28,584,500.00 | 28,584,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 00.00 | 7,714,500.00 | 7,950,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 10,000,000.00 | 10,250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,721,000.00 | 4,721,000.00 | 10,870,000.00 | 10,384,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны** | 611,000.00 | 611,000.00 | 1,387,000.00 | 1,387,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 611,000.00 | 611,000.00 | 1,387,000.00 | 1,387,000.00 |
| **2108** | **БГАҮ-ний хураамж** | 1,398,500.00 | 1,398,500.00 | 3,393,400.00 | 3,393,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэт/сэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,398,500.00 | 1,398,500.00 | 2,793,400.00 | 2,793,400.00 |
| 210802 | Аудит, баталгаа-жуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 600,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16815200.00 | 16815200.00 | 26491100.00 | 26491100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,995,500.00 | 10,995,500.00 | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,819,700.00 | 5,819,700.00 | 18,491,100.00 | 18,491,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 168808923.00 | 168808923.00 | 114091200.00 | 113431850.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 168,808,923.00 | 168,808,923.00 | 114,091,200.00 | 113,431,850.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4,651,573.00 | 4,651,573.00 | 00.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 101,365,850.00 | 101,365,850.00 | 107,080,000.00 | 106,421,550.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 61,791,500.00 | 61,791,500.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | 7,011,200.00 | 7,010,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,912,465,496.00 | 1,912,465,496.00 | 2,337,172,200.00 | 2,334,495,628.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,904,885,663.00 | 1,904,885,663.00 | 2,018,033,600.00 | 2,015,357,028.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс сан/жих | 1,904,885,663.00 | 1,904,885,663.00 | 2,018,033,600.00 | 2,015,357,028.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 319,138,600.00 | 319,138,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 319,138,600.00 | 319,138,600.00 |
| **1340** | НДС-гаас ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,651,573.00 | 4,651,573.00 | 00.00 | |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,651,573.00 | 4,651,573.00 | 00.00 | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛ ЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,928,260.00 | 2,928,260.00 | 00.00 | 00.00 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,928,260.00 | 2,928,260.00 | 00.00 | 00.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01 | 01 | 01 | 01 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01 | 01 | 01 | 01 |
| **62** | **АЖИЛЛАГСАД** | 139 | 137 | 142 | 148 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 103 | 101 | 104 | 109 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 35 | 35 | 37 | 38 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 2,188 | 2,188 | 2,422 | 2,422 |
| 630 | СУРАЛЦАГЧИД | 2,100 | 2,181 | 2,444 | 2,422 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2,100 | 2,181 | 2,444 | 2,422 |
| 65 | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **139** | **137** | **142** | **148** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловс-ролын албан хаагч (ТҮБД) | 111 | 109 | 113 | 119 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 2 | 2 | 2 | 2 |
| 650009 | Төрийн үйлчил-гээний бусад албан хаагч (ТҮ) | 26 | 26 | 27 | 27 |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **38320286.70** | **38,143,694.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **38320286.70** | **38,143,694.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 38320286.70 | 28,043,994.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38320286.70 | 28,043,994.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38320286.70 | 28,043,994.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 10099700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 10,099,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 10,099,700.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 10099700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 10,099,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,099,700.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

6417113544
ВЮА0067 9007423